

МОНГОЛБАНКНААС БАРИМТЛАХ ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМИЙН БОДЛОГО

1. ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМД МОНГОЛБАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

- 1.1. Монголбанк нь үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлж, төлбөрийн системийн аюулгүй, найдвартай, тасралтгүй байдал, жигд ажиллагааг хангах үүрэгтэй.
- 1.2. Төлбөр тооцооны системийн үр ашигтай, найдвартай байдлыг хангах зорилгоор холбогдох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.3. Төлбөр тооцооны системийн дүрэм, журмыг Олон Улсын Төлбөр Тооцооны Банкнаас гаргасан суурь зарчмууд, зөвлөмжийн дагуу боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.4. Үндэсний төлбөр тооцооны системийн хөгжлийн стратеги баримт бичгийг боловсруулах, эн тэргүүний болон хэтийн зорилтыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар баталж, хэрэгжүүлнэ.
- 1.5. Төв банкны тухай хуульд заасны дагуу Монголбанк нь төлбөр тооцооны системтэй холбоотой дараахь үйл ажиллагааг эрхэлнэ:
 - үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах замаар бэлэн мөнгөөр хийх төлбөр тооцоог зохион байгуулах,
 - банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, гүйцэтгэх.

2. БАНК ХООРОНДЫН ТӨЛБӨР ТООЦООГ ГҮЙЦЭТГЭХ

2.1. Монголбанк нь банкуудад үйлчилгээ үзүүлэх замаар банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Монголбанкны Төлбөр Тооцооны Төв \ТТТ\ нь банк хоорондын их, бага дүнтэй төлбөр тооцоог дамжуулан гүйцэтгэх гол механизм билээ. ТТТ нь банкуудаас төлбөр тооцооны мэдээллийг зөвхөн цахим хэлбэрээр хүлээн авч, боловсруулан банк хооронд дамжуулдаг санхүүгийн дундын сүлжээ юм.

2.2. Төлбөр тооцоог өдөрт нь багтаан гүйцэтгэж, үр дүнг нь харилцан суутгах суурь зарчмын дагуу:

- ТТТ нь банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээг түргэн шуурхай дамжуулах,
- Монголбанкны Төлбөр Тооцоо, Бүртгэлийн Газар нь төлбөр тооцооны үр дүнг өдөрт нь багтаан харилцан суутгаж, дуусгавар болгоно.

ТТТ нь төлбөр тооцооны системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор нөөц төвийг ажиллуулна.

2.3. Банкууд нь Монголбанкинд харилцах данстай байх бөгөөд түүгээр дамжуулан банк хоорондын төлбөр тооцоогоо гүйцэтгэх, төлбөр тооцоог саадгүй дамжуулахад шаардагдах зээл авна. Монголбанкин дахь харилцах дансаар дамжуулан төлбөр тооцоо гүйцэтгэх нь хамгийн найдвартай хэлбэр бөгөөд төлбөр тооцоог гүйцэтгэх эх үүсвэрийг төв банк баталгаажуулж байгаа нь системийн оролцогчийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлж, зээлийн эрсдлийг бууруулна.

2.4. Монголбанк нь төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд анхаарч, банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээг бодит цагийн горимд шилжүүлнэ. Бодит цагийн горим нь системийн оролцогчдын төлбөрийн чадварыг дээшлүүлэх, зээлийн эрсдлийг бууруулах, банкууд төлбөр тооцоогоо шуурхай гүйцэтгэх, төлбөрийн чадвар, дансны үлдэгдэл болон төлбөр тооцооны урсгалыг бодит цагийн горимоор хянах боломжийг олгоно. Бодит цагийн горимд шилжсэнээр банкуудын төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс Монголбанк нь өдрийн зээлийг барьцаат зээлийн зарчмаар олгоно.

3. СИСТЕМИЙН ХУВЬД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ /ИХ ДҮНТЭЙ ТӨЛБӨР ТООЦОО/

- 3.1. Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэхээс гадна системийн үйл ажиллагаанд хяналт тавина. Төлбөр тооцооны системийн хяналтыг хийж системийн оролцогч болон нийлүүлэгч байгууллагуудад учирч болох эрсдлийн талаар тодорхой ойлголт өгөх замаар системийн эрсдлийг бууруулна.
- 3.2. Монголбанк нь Олон Улсын Төлбөр Тооцооны Банкны Төлбөр Тооцооны Системийн Хорооноос гаргасан “Системийн хувьд чухал ач холбогдол бүхий төлбөрийн системийн суурь зарчмууд”-ыг баримтална.
- 3.3. Үндэсний төлбөр тооцооны системийг хөгжүүлэх стратеги баримт бичиг, бодлого, эн тэргүүний болон хэтийн зорилт, холбогдох дүрэм, журам, үндсэн зарчмуудыг Монголбанк нь Төлбөр Тооцооны Үндэсний Зөвлөлтэй хамтран боловсруулж, батлах бөгөөд оролцогч талуудын хоорондын харилцааг зохицуулах, учирч болох эрсдлийг бууруулах талаар тодорхой заана.
- 3.4. Төлбөр тооцооны журамд Монголбанкны зүгээс өөрчлөлт оруулж болох бөгөөд үүний тулд системийн оролцогч талууд болон бусад холбогдох талуудтай урьдчилан зөвшилцөж, тохиролцоонд хүрнэ.
- 3.5. Монголбанк нь төлбөр тооцоотой холбоотой асуудлыг амжилттай шийдэхийн тулд Төлбөр Тооцооны Үндэсний Зөвлөл, системийн оролцогчидтой хамтран ажиллах зарчмыг баримтлана.
- 3.6. Монголбанк нь системийн хувьд чухал ач холбогдол бүхий төлбөрийн системийн эрсдлийн удирдлагын талаар тогтмол анхаарч, хяналт тавина.

4. БАГА ДҮНТЭЙ ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Бага дүнтэй төлбөр тооцоо нь нийт системийг хамарч болохуйц эрсдлийг үүсгэх чухал шалтгаан болдоггүй ч олон тооны хэрэглэгчийг хамарч байдаг тул түүнээс үүсэх эрсдэл нь төлбөр тооцооны системд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж болзошгүй. Суурь зарчмууд нь системийн хувьд чухал ач холбогдол бүхий төлбөрийн системийг үнэлэх зорилготой боловч бага дүнтэй гүйлгээний системийн үр ашигтай байдлыг дээшлүүлэх үүднээс хяналтыг дээрх суурь зарчмуудын дагуу хийнэ.
- 4.2. Монголбанк нь бага дүнтэй гүйлгээ дамжуулж, клиринг хийж байгаа операторуудад төлбөрийн системийн эрсдлийн талаар зөвлөгөө өгч тэдгээрээс хүсэлт гаргасан тохиолдолд тухайн төлбөрийн систем нь Суурь зарчмуудтай нийцэж байгаа эсэх, системийн үйл ажиллагаа, түүний хөгжилтэй холбоотой бусад тодорхой асуудлаар саналаа илэрхийлнэ. Монголбанк нь бага дүнтэй гүйлгээний систем болон клирингийн үйл ажиллагааны талаарх төсөл боловсруулах, санал солилцоход оролцоно.
- 4.3. Монголбанк нь төлбөр тооцооны системийн тоон мэдээллийг тогтмол бэлтгэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл системийн үйл ажиллагаа ба эрсдлийн талаар баримталж буй дүрэм, журам, зарчим болон бусад холбогдох баримт бичиг, мэдээллийг төлбөр тооцооны системийн оролцогчдоос гаргуулж болно.

5. ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛҮҮД

- 5.1. Бэлэн мөнгөний хэрэглээг багасгаж, бэлэн бус төлбөр тооцооны шинэ дэвшилтэд хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэх, түүний хэрэглээг өргөжүүлэх нь төлбөр тооцооны системийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 5.2. Зах зээлд шинээр нэвтэрч байгаа цахим төлбөрийн хэрэгслүүд, төлбөрийн карт, цахим банкны үйлчилгээний хүрээг тэлж, төлбөрийн шинэ хэрэгслүүдийг ашигласнаар төлбөр нь цаг хугацаандаа найдвартай хийгдэх боломжийг нэмэгдүүлнэ.

5.3. Монголбанк нь Монгол Улсад хэрэглэгдэж буй төлбөрийн хэрэгслүүдийн талаарх мэдээллийг нэгтгэж, судалгааг хийнэ. Төлбөрийн аливаа хэрэгслийн хэрэглээ өсөн нэмэгдэхийн сацуу үндэсний төлбөр тооцооны системд эрсдэл учруулахуйц нөхцөл үүсвэл Монголбанк түүний хэрэглээний зохицуулалтыг хийж, зөвлөмж гаргаж, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гаргахад оролцоно.

5.4. Монголбанк төлбөрийн шинэ хэрэгсэл нэвтрүүлэх, хөгжүүлэхэд системийн оролцогчидтой хамтран ажиллана. Төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлж буй талууд болон бусад сонирхогч талуудын хүсэлтээр Монголбанк тухайн төлбөрийн хэрэгслийн хөгжил, түүнтэй холбогдох эрсдлийн талаар санал бодлоо илэрхийлж болно.

6. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТ

6.1. Төлбөр тооцооны системийн жигд ажиллагаанд Монголбанк хяналт тавина. Хяналт нь төлбөр тооцооны системийн үр ашигтай, найдвартай ажиллагааг хангах, төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой.

6.2. Хяналт нь холбогдох дүрэм, журмын биелэлтийг хангуулах гол хэлбэр юм. Төв банк нь төлбөр тооцооны системийн оролцогчдод тодорхой шалгуур тогтоож, зайлшгүй гэж үзсэн тохиолдолд, төлбөр тооцооны системийн оролцогч банк, банк бус санхүүгийн байгууллагад хяналтын шалгалтыг хийнэ.

6.3. Төлбөр тооцооны системийн эрсдлийг бууруулах үүднээс хяналтыг нийт системээр болон системийн оролцогч тус бүрээр гүйцэтгэнэ.

6.4. Төлбөрийн системийн эрсдлийг дараахь байдлаар ангилна:

- зээлийн эрсдэл,
- төлбөрийн чадварын эрсдэл,
- хуулийн эрсдэл,
- үйл ажиллагааны эрсдэл,
- системийн эрсдэл.

Төлбөрийн системийн эрсдлүүд

- **Зээлийн эрсдэл:** төлбөр тооцооны системд оролцогч тал тухайн үед эсвэл ирээдүйд санхүүгийн үүргээ хүлээх боломжгүй болох,
- **Төлбөрийн чадварын эрсдэл:** төлбөр тооцооны системд оролцогч тал санхүүгийн үүргээ тухайн үед биелүүлэхгүй, хожим хэзээ нэгэн цагт биелүүлэх (энэ тохиолдолд төлбөр тооцооны системд оролцогч нөгөө тал уг эрсдлийг үүрнэ),
- **Хууль зүйн эрсдэл:** төлбөрийн системийн хууль эрх зүйн орчин ядмаг байх, байгуулсан гэрээ хэлэлцээрийг зөрчих,
- **Үйл ажиллагааны эрсдэл:** техникийн алдаа, байгалийн гамшиг, хувь хүний хариуцлага, луйврын шинж чанар, мөн түүнчлэн компьютерийн системийн гэмтэл зэрэг төлбөр тооцооны үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл,
- **Системийн эрсдэл:** төлбөрийн системд оролцогч аливаа нэг тал өөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсноор системийн бусад оролцогч талуудын төлбөрийн чадварыг алдагдуулах эрсдэл (системийн оролцогч нэг талын дампуурал домино нөлөөлөл үүсгэж болно, цаашилбал системийн болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болно).

6.5. Монголбанк нь төлбөр тооцооны системийн хяналтыг хийх үндсэн зарчмуудыг Олон Улсын Төлбөр Тооцооны Банкнаас гаргасан “Төв банкнаас баримтлах төлбөр тооцооны системийн хяналтын зарчим”-уудын дагуу тодорхойлно:

Хяналтын Зарчим 1: Нээлттэй, ил тод бодлого

Төв банк нь төлбөр тооцооны системийн стандарт болон бодлогын шаардлагыг тодорхойлсон хяналтын бодлогыг нийтэд ил тод байдлаар хэрэгжүүлэх.

Хяналтын Зарчим 2: Олон улсын стандарт

Төв банк нь төлбөр тооцооны системийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг өөрийн орны төлбөр тооцооны системийн үйл ажиллагаанд уялдуулан хэрэгжүүлэх.

Хяналтын Зарчим 3: Эрх мэдэл ба чадвартай байх

Төв банк нь хяналтын үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрх мэдэл ба чадвартай байх.

Хяналтын Зарчим 4: Тасралтгүй ажиллагаа

Хяналтын стандартуудыг Төв банкны төлбөр тооцооны системийг оролцуулан бусад төлбөрийн системийн бүхий л хүрээнд тасралтгүй мөрдүүлэх.

Хяналтын Зарчим 5: Бусад байгууллагуудтай хамтран ажиллах

Төв банк нь төлбөрийн системийн аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг дэмжих үүднээс бусад орны төв банкууд болон дотоод гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах (Lamfalussy Standards¹).

7. ХЯНАЛТЫН БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ

7.1. Монголбанк нь системийн эрсдлийг бууруулах зорилгоор төлбөр тооцооны системийн хяналтыг хийнэ. Төлбөрийн системийн оролцогч талуудын санхүүгийн чадвар /ялангуяа банкуудын/ төлбөрийн системд эрсдэлд учруулахуйц нөлөө үзүүлэхээр бол Монголбанкнаас хяналт шалгалтыг хийхдээ эрх бүхий бусад санхүүгийн хяналтын байгууллагууд /Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт/ - тай хамтран хэрэгжүүлнэ.

7.2. Монголбанк нь эрх бүхий бусад байгууллагуудтай хамтарч ажиллахдаа шаардлагатай мэдээллийг чөлөөтэй солилцох гэрээ байгуулан ажиллана. Хамтран ажиллах гэрээний дагуу төлбөрийн системийн оролцогчид холбогдох дүрэм, журам, горим, зарчмыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ. Шаардлагатай гэж үзвэл, хэрэглэгчид болон төлбөрийн системийн бусад оролцогчдоос өөрийн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг шалгаж болно.

¹ Lamfalussy Standards – Төлбөр тооцооны системийн хяналтын олон улсын хамтын ажиллагааны зарчим, 1990 он.

7.3. Монголбанк төлбөр тооцооны системийн хяналт болон бусад холбогдолтой асуудлаар гадаадын төв банкууд, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллана.

8. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

8.1. Төлбөр тооцооны системийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төлбөрийн хэрэгслийн хэрэглээ, системийн үйл ажиллагаа, түүний хяналтын талаарх мэдээлэл, тоон үзүүлэлтийн судалгааг агуулсан төлбөрийн системийн хөгжлийн тоймыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан мэдээлнэ.

8.2. Төлбөрийн системтэй холбоотой эрх зүйн баримт материал, холбогдох журам, дүрмийг Монголбанкны веб хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ. Мөн өөрийн орны төлбөрийн системийн талаарх мэдээллийг гадаадын олон улсын байгууллагуудад хүргэж, хэвлэн нийтлүүлж болно.

МОНГОЛБАНК